



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

“Унгарын соёлын өдрүүд” арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай” 333 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09, 02/10 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/530 дугаар захирамж, тус газрын 2022 оны дүрмийн 4.1.8, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, хоёр орны аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаа, Унгар улсаас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, Унгар улсын соёлыг түгээх зорилгоор “Унгарын соёлын өдрүүд” арга хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

2. “Унгарын соёлын өдрүүд”-ийг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.


3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 19 700 000 /арван есөн сая долоон зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /В.Батчимэг/-т даалгасугай.



1150500761


Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 04 сарын 18 өдрийн
A117 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“УНГАРЫН СОЁЛЫН ӨДРҮҮД” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
В.Батчимэг	
Гишүүд:	Маркетинг, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
С.Туул	Унгарын Элчин сайдын Нарийн бичгийн дарга
Г.Хишигбадам	Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Т.Туул	Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн
Б.Цолмонгэрэл	Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд хариуцсан менежер
Б.Баярцэнгэл	Мэдээллийн ажилтан
Б.Хос-Эрдэнэ	
Б.Ишдорж	Мэдээллийн технологи, цахим хөгжил хариуцсан ажилтан
Нарийн бичгийн дарга:	Эвент хариуцсан мэргэжилтэн
Б.Халиун	

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 07 сарын 18 өдрийн
А/А дугаар тушаалын хөёрдугаар хавсралт



“УНГАРЫН СОЁЛЫН ӨДРҮҮД” АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Талбайн тохижилтын зардал /тайз, хөгжим техник/	Багц	8.000.000	8.000.000
2	Хөтлөгчийн зардал	Хүн/өдөр 1/2	1.000 000	1.000.000
3	Урлагийн тоглолт	Багц	4.500.000	4.500.000
3	Маркетинг, сурталчилгаа /шторк, контент бэлтгэх /	Багц	5.000.000	5.000.000
4	Асар майхан түрээс /4*4 хэмжээтэй/	10ш/1 өдөр	120.000	1.200.000
Нийт дүн				19.700.000

--- ооОоо ---